



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 01 сарын 27 өдөр

Дугаар 5/80

Хэрлэн сум

Сахилгын шийтгэл ногдуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6, Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.1, 131.1.2, Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйл, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.8 дахь заалт, Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газрын удирдлага, мэргэжилтнүүд, сумын Засаг дарга аймгийн Засаг даргын дэргэдэх агентлагийн дарга нар гадаад, дотоодод томилолтоор ажиллах удирдамж, үр дүнг тайлагнах журмын 4.1, 4.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэнтий аймгийн Засаг даргын нэрэмжит бэлэн байдлын үзлэгт өөрийн хариуцсан сум орон нутгийн тусгай мэргэжлийн анги, аж ахуй нэгж, байгууллагын ой хээрийн түймэртэй тэмцэх бэлтгэл бэлэн байдлыг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллаагүй, аймгийн Засаг даргын нэрэмжит бэлэн байдлын үзлэгт өөрийн биеэр оролцож чадахгүй болсныг урьдчилан мэдэгдээгүй Батноров сумын Засаг дарга /Г.Тайванжаргал/, Жаргалтхаан сумын Засаг дарга /Б.Цогт-Орших/, Өмнөдэлгэр сумын Засаг дарга /Б.Эрдэнэбаатар/, Дархан сумын Засаг дарга /Ж.Энхтөр/ нарыг албан тушаалын цалинг 1 сар 10 хувиар хасаж сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Албан үүргээ холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд биелүүлж ажиллахыг Батноров сумын Засаг дарга /Г.Тайванжаргал/, Жаргалтхаан сумын Засаг дарга /Б.Цогт-Орших/, Өмнөдэлгэр сумын Засаг дарга /Б.Эрдэнэбаатар/, Дархан сумын Засаг дарга /Ж.Энхтөр/ нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

01 891